



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/11-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Д.Чулуунцэцэг
Утас: 70362442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.Аудитын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.4.4 Үндсэн хөрөнгө.....	15
3.4.5 Өр төлбөр.....	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.4.8 Зардлын данс.....	19
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт	
5.2 Албан шаардлага.....	24
5.3 Зөвлөмж.....	26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



САЙХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.МӨНХБОЛД ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.23 № САА-2024/11-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ИТХ-ын “Сайхан сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 20 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 3,515,916.5 мянган төгрөгөөр эцэслэн баталснаас гүйцэтгэлээр 4,022,434.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 14.4 хувиар давуулсан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сайхан сумын ЗДТГ-ын төрийн захиргааны албан хаагчийн орон тоог 2023 онд 21 байхаар төлөвлөж, баталсан боловч гүйцэтгэлээр 9 орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин, НДШ-ийн зардлыг 137,468.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сайхан сумын Засаг дарга нь тайлант онд 12 зорилт, 178 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.8 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан***Имянган төгрөгөөр!*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,171,594.20	2,073,719.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,878,428.20	1,582,601.90
33	АВЛАГА	245,732.50	403,082.20
35	БАРАА МАТЕРИАЛ	47,433.40	88,035.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,501,569.10	5,380,787.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,501,569.10	5,380,787.10
39200	Биет хөрөнгө	4,025,138.80	4,830,014.40
39300	Биет бус хөрөнгө	476,430.30	550,772.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,673,163.30	7,454,506.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,094.60	15,031.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,094.60	15,031.10
41300	Өглөг	10,094.60	15,031.10
41400	Урьдчилж орсон орлого	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,663,068.70	7,439,475.70
51	Засгийн газрын хувь оролцоо	6,663,068.70	7,439,475.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	718,195.50	600,854.20
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	191,800.90
51200	Хуримтлагдсан үр дүн	5,061,701.60	5,763,648.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	883,171.70	883,171.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,673,163.30	7,454,506.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Имянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,955,188.40	6,271,932.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,944,113.40	3,715,659.40
110	Орлогын албан татвар	2,910,839.40	2,766,978.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,910,839.40	2,980,609.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-213,630.30
113	Хөрөнгийн албан татвар	681,223.60	589,238.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	352,050.40	359,441.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,328,888.60	1,640,318.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,328,888.60	1,640,318.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,682,186.30	915,954.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,887,953.10	4,507,575.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,887,953.10	4,444,238.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,609,931.60	4,441,608.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,451.90	822,621.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,254.50	102,194.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,923,564.90	72,998.10
2104	Хангамж, бараа материалын зардал	52,660.60	78,329.50
2105	Нормативт зардал	1,558.90	523.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,177.20	46,399.20
2107	Томилолт, зочны зардал	4,101.80	8,313.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,942.20	2,241,942.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	509,219.70	1,068,288.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,278,021.50	2,630.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	63,337.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,067,235.20	1,764,356.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,123,133.50	1,062,408.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-10,055,898.30	701,947.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Имянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,791,427.50	16,791,427.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-72,460.50	-72,460.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,718,967.00	16,718,967.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0
9	Тайлант үеийн үр дүн	-10,055,898.30	-10,055,898.30
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,663,068.70	6,663,068.70
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,663,068.70	6,663,068.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,663,068.70	6,663,068.70
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	74,459.60	74,459.60
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0
19	Тайлант үеийн үр дүн	701,947.30	701,947.30
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	7,439,475.70	7,439,475.70

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Имянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,933,504.40	5,062,642.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,944,113.40	3,715,659.40
110	Орлогын албан татвар	2,910,839.40	2,766,978.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,910,839.40	2,980,609.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-213,630.30
113	Хөрөнгийн албан татвар	681,223.60	589,238.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	352,050.40	359,441.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	103,239.20	98,109.80
1181	Газрын төлбөр	245,010.30	257,924.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,800.90	3,407.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	307,204.80	431,029.00
120	Нийтлэг татварын бус орлого	307,204.80	431,029.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,682,186.30	915,954.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,578,706.30	3,929,705.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,578,706.30	3,929,705.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,294,689.10	3,927,075.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,179.40	822,893.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,254.50	102,194.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,923,564.90	72,998.10

2104	Хангамж, бараа материалын зардал	53,425.50	65,133.60
2105	Нормативт зардал	1,558.90	360
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,928.70	42,467.00
2107	Томилолт, зочны зардал	4,101.80	8,313.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,819.80	2,242,350.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,855.60	570,365.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,284,017.20	2,630.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,354,798.10	1,132,936.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	970,321.20	1,180,363.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	970,321.20	1,180,363.00
2200	Дотоод эх үүсвэрээр	970,321.20	1,180,363.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-970,321.20	-1,180,363.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-248,400.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	248,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,384,476.90	-295,826.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	493,951.30	1,878,428.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,878,428.20	1,582,601.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Имянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,505,945.6	5,331,616.3	1,174,329.3	81.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,285,133.2	3,961,679.2	323,454.0	92.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,254,594.8	3,959,049.2	295,545.6	93.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,977.7	822,893.7	120,084.0	87.3
210101	Үндсэн цалин	521698.5	472265.8	49,432.7	90.5
210102	Нэмэгдэл	351006.5	234335.0	116,671.5	66.8
210103	Урамшуулал	10042.4	49359.8	-39,317.4	491.5
210104	Гэрээт ажлын хөлс	60230.3	66933.1	-6,702.8	111.1
2102	Ажил олгогчоос НДШ	119,578.8	102,194.0	17,384.8	85.5
210201	Тэтгэврийн даатгал	81555.8	70057.1	11,498.7	85.9
210202	Тэтгэмжийн даатгал	9585.4	8213.3	1,372.1	85.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	9866.1	6561.9	3,304.2	66.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1944.3	1617.4	326.9	83.2
210205	Эрүүл мэндийн даатгал	16627.2	15744.3	882.9	94.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,132,705.1	2,115,084.1	17,621.0	99.2
210301	Гэрэл, цахилгаан	121394.8	109338.9	12,055.9	90.1
210302	Түлш, халаалт	1887670.7	1885867.8	1,802.9	99.9
210303	Цэвэр, бохир ус	123639.6	119877.4	3,762.2	97.0
2104	Хангамж, бараа материалын зардал	80,678.6	60,368.9	20,309.7	74.8

210401	Бичиг хэрэг	15841.6	12841.8	2,999.8	81.1
210402	Тээвэр, шатахуун	36371	31558.5	4,812.5	86.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8455.3	6009.7	2,445.6	71.1
210404	Ном, хэвлэл	282.4	375.5	-93.1	133.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1046.4	0	1,046.4	0.0
210406	БҮТЭЭ	18681.9	9583.4	9,098.5	51.3
2105	Нормативт зардал	666.3	100.0	566.3	15.0
210502	Хоол, хүнс	666.3	100.0	566.3	15.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	271,538.2	243,364.3	28,173.9	89.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	42149.1	41960.4	188.7	99.6
210602	Тавилга	2849.6	1610.0	1,239.6	56.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	778.3	0	778.3	0.0
210604	Урсгал засвар	225761.2	199793.9	25,967.3	88.5
2107	Томилолт, зочны зардал	8,506.2	8,313.5	192.7	97.7
210702	Дотоод албан томилолт	8,506.2	8,313.5	192.7	97.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,973.5	41,627.7	7,345.8	85.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	43942.6	38931.1	5,011.5	88.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	454.6	0	454.6	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	974.5	863.0	111.5	88.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	570.0	187.3	382.7	32.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	290.9	88.0	202.9	30.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2038.3	1356.0	682.3	66.5
210807	Газрын төлбөр	533.7	64.7	469.0	12.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2.5	0	2.5	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	166.4	137.6	28.8	82.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	648,970.4	565,103.0	83,867.4	87.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	645103.9	564575.5	80,528.4	87.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3866.5	527.5	3,339.0	13.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,538.4	2,630.0	27,908.4	8.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,538.4	2,630.0	27,908.4	8.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,500.0	0.0	25,500.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,038.4	2,630.0	2,408.4	52.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	894,396.6	1,121,537.1	-227,140.5	125.4
220001	Барилга байгууламж	745896.6	942753.9	-196,857.3	126.4
221001	Их засвар	65000.0	63337.3	1,662.7	97.4
222001	Тоног төхөөрөмж	83500.0	114780.0	-31,280.0	137.5
223001	Бусад хөрөнгө	0.0	665.9	-665.9	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	267,860.0	248,400.0	19,460.0	92.7
230001	Эргэж төлөгдөх зээл	267,860.0	248,400.0	19,460.0	92.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,447,389.8	5,490,821.5	-43,431.7	100.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,174,789.8	5,367,567.4	-192,777.6	103.7

320001	Орон нутгийн төсвөөс	5,174,789.8	4542289.0	632,500.8	87.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	825278.4	-825,278.4	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	272,600.0	742,068.3	-469,468.3	45.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,600.0	123254.1	149,345.9	45.2
350002	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	229804.5	-229,804.5	0.0
350003	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	389009.7	-389,009.7	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	105.0	89.0	16.0	84.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	3.0	3.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	53.0	41.0	11.0	77.3
620001	Удирдах ажилтан	8.0	8.0	0.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	21.0	12.0	9.0	
620003	Үйлчлэх ажилтан	22.0	21.0	1.0	
620004	Гэрээт ажилтан	2.0	1.0	1.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,569.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,565.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,565.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,760.7
210401	Бичиг хэрэг	2,435.5
210402	Тээвэр, шатахуун	2,178.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	136.5
2105	Нормативт зардал	260.0
210502	Хоол, хүнс	260.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,565.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,565.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,980.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,830.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,569.7
	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,569.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,368.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,796.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,405.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2022-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нутагшуулах;
- Үйлдвэр, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*

ТТЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сумын төсөвт байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 781,343.5 мянган төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,878,428.2	1,582,601.9	-295,826.3
Авлага	245,732.5	403,082.2	157,349.7
Бараа материал	47,433.4	88,035.5	40,602.1
Үндсэн хөрөнгө	4,501,569.1	5,380,787.1	879,218.0
Нийт хөрөнгө	6,673,163.2	7,454,506.7	781,343.5
Өр төлбөр	10,094.6	15,031.1	4,936.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,663,068.7	7,439,475.7	776,407.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,673,163.3	7,454,506.8	781,343.5

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,582,601.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 295,826.3 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	1,878,428.2	1,582,601.9	-295,826.3
Дүн	1,878,428.2	1,582,601.9	-295,826.3

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын дансны 1,191,029.7 мянган төгрөг, ОНХС-ийн дансны 292,205.9 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн 96,803.8 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны 2,562.5 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 403,082.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 157,349.7 мянган төгрөгөөр буюу 64.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	13,593.7	30,807.9	17,214.2
Байгууллагаас авах авлага	0.0	0.0	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	6,066.7	6,066.7	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	226,072.1	366,207.6	140,135.5
Дүн	245,732.5	403,082.2	157,349.7

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн 397,015.5 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 6,066.7 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 98.5 хувь буюу 397,015.5 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 38 иргэний 137,125.3 мянган төгрөгийн авлагаас ШШГГ-т гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 11 иргэний 33,297.2 мянган төгрөгийн зээл, шүүхийн эвлэрүүлэн зуучлах шийдвэрийн дагуу эвлэрлийн гэрээ байгуулан төлөлт хийгдэж байгаа 5 иргэний 32,982.1 мянган төгрөгийн зээл хуваарийн дагуу төлөгдөж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 88,035.5 мянган төгрөг болж өмнөх оноос 40,602.10 мянган төгрөгөөр буюу 85.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0.0	59,500.0	59,500.0
Бичиг хэргийн материал	1,426.3	1,256.3	-170.0
Аж ахуйн материал	43,030.5	26,162.5	-16,868.0
Сэлбэг хэрэгсэл	730.0	730.0	0.0
Бусад хангамжийн материал	2,246.6	316.7	-1,929.9
Түлш шатах тослох материал	0.0	70.0	70.0
Дүн	47,433.4	88,035.5	40,602.1

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 40,602.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 204,820.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 59,500.0 мянган төгрөгийн бараа материалыг өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн бүртгэж, 223,718.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,380,787.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 879,218.0 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,025,138.80	4,830,014.40	804,875.60
Барилга, байгууламж, орон сууц	1,059,943.20	1,065,958.30	6,015.10
Авто-тээврийн хэрэгсэл	44,770.70	103,670.80	58,900.10
Машин тоног төхөөрөмж(компьютер)	76,461.80	101,477.90	25,016.10
Тавилга, аж ахуйн эд хогшил	26,826.10	23,691.90	-3,134.20
Зам гүүрийн байгууламж	136,663.40	426,832.00	290,168.60
Дуусаагүй барилга	0.00	0.00	0.00
Номын фонд	0.00	0	0.00
Түүх соёлын дурсгалт зүйл	59500	0	-59,500.00
Бусад үндсэн хөрөнгө	2,620,973.60	3,108,383.50	487,409.90
Биет бус хөрөнгө	476,430.30	550,772.70	74,342.40
Программ хангамж	117.20	0.00	-117.20
Бусад биет бус хөрөнгө	476,313.10	550,772.70	74,459.60
Дүн	4,501,569.10	5,380,787.10	879,218.00

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 879,218 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 58,825.9 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, үнэ төлбөргүй орлогоор 1,282,035.1 мянган төгрөгийн /аймгийн замын сангийн хөрөнгөөр Номгон тосгонд хийгдсэн 302,618.1 мянган төгрөгийн өртөгтэй хатуу хучилттай зам, Сайхан суманд хийгдсэн 666,709.1 мянган төгрөгийн өртөгтэй хатуу хучилттай зам, хот тохижилтын газарт 79,800.0 өртөгтэй өргөгчтэй кран, 232,907.9 мянган төгрөгийн өртөгтэй гудамжны гэрэлтүүлэг, явган хүний зам болон хүүхдийн тоглоомын талбай/ хөрөнгийг бүртгэн авсан болон сумын ИТХ-ын 2023 оны 26, 28, 29, 33 дугаар тогтоолуудыг үндэслэн нийт 22,109.9 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 59,500.0 мянган төгрөгийн /шаазан шавар бурхад/ бараа материалыг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 15,031.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,936.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	0.0	0.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0		0.0
Байгууллагад төлөх өглөг	10,094.6	15,031.1	4,936.5
Дүн	10,094.6	15,031.1	4,936.5

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгийн дансны 2,562.5 мянган төгрөг, Биеийн тамирын спортын цогцолборын тогтмол зардлын 6,677.3 мянган төгрөг, ОНХС-ийн хөгжүүлэх сангийн тодорхой бус / иргэнээс шилжиж орж ирсэн / 4,209.0 мянган төгрөгийн өглөг, орон нутгийн ерөнхий орлогын 1,582.4 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,439,475.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 776,407.0 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	718,195.5	792,655.1	74,459.6
Хуримтлагдсан үр дүн	5,944,873.2	6,646,820.6	701,947.4
Өмнөх үеийн үр дүн	15,117,599.8	5,061,701.6	-10,055,898.2
Тайлант үеийн үр дүн	-10,055,898.3	701,947.3	10,757,845.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	883,171.7	883,171.7	0.0
Дүн	6,663,068.7	7,439,475.7	776,407.0

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 776,407.0 мянган төгрөг ба өмнөх оноос 776,407.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 20 дугаар “Сайхан сумын 2023 оны төсөв тодотгон батлах” тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 3,515,916.5 мянган төгрөгөөр эцэслэн баталснаас гүйцэтгэлээр 4,022,434.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 14.4 хувиар давуулсан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төсвийн орлогын гүйцэтгэл

№	Татварын нэр төрөл	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татварын орлого	3,515,916.5	4,022,434.2	506,517.7	114.4
2	Хүн амын орлогын албан татвар	2,492,869.7	2,766,978.8	274,109.1	142.6
3	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	2,520,000.0	2,644,785.6	124,785.6	105.0
4	Үйл ажиллагааны орлого	41,000.0	77,292.2	36,292.2	188.5
5	ХХОА татварын буцаалт	-213,630.3	-213,630.3	0.0	100.0
6	Хөрөнгө борлуулсны орлого	71,500.0	87,956.0	16,456.0	123.0
7	Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	74,000.0	170,575.3	96,575.3	230.5
8	Хөрөнгийн албан татвар	728,101.8	589,238.7	-138,863.1	80.9
9	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	500,000.0	475,269.8	-24,730.2	95.1
10	Бууны албан татвар	2,100.0	1,273.0	-827.0	60.6
11	Малд ноогдуулах албан татвар	226,001.8	112,695.9	-113,305.9	49.9
12	Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	64,000.0	98,109.9	34,109.9	153.3
13	Улсын тэмдэгтийн хураамж	25,000.0	28,639.2	3,639.2	114.6
14	Хог хаягдлын хураамжийн орлого	34,000.0	61,102.9	27,102.9	179.7
15	ТТАМАТөлбөр	5,000.0	8,367.8	3,367.8	167.4
16	Газрын төлбөр	89,195.0	257,924.5	168,729.5	289.2
17	Газрын дуудлага худалдаа	40,000.0	204,276.4	164,276.4	510.7
18	Газрын төлбөр	49,195.0	53,648.1	4,453.1	109.1
19	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,750.0	3,407.5	1,657.5	194.7
20	Ойн нөөц ашигласны төлбөр	0.0	129.5	129.5	
21	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,750.0	3,278.0	1,528.0	187.3
22	Татварын бус бусад орлого	140,000.0	306,774.8	166,774.8	219.1
23	нэр заагаагүй бусад орлого	20,000.0	27,594.9	7,594.9	138.0
24	Хүү, торгуулийн орлого	120,000.0	279,179.9	159,179.9	232.6
	Нийт дүн	3,515,916.5	4,022,434.2	506,517.7	114.4

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хүн амын орлогын албан татвар 274,109.1 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 3,639.2 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 164,276.4 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 27,102.9 мянган төгрөгөөр татварын бус бусад орлого 166,774.8 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын гүйцэтгэлээр хөрөнгийн албан татвар 138,863.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нэмэгдсэн.
- ✓ **Хог хаягдлын хураамжийн орлого:** Сумын ИТХ-ын 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 53 дугаар тогтоолоор хуурай хог хаягдлын хураамжийн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоосонтой холбоотойгоор орлого нэмэгдсэн.
- ✓ **Газрын дуудлага худалдааны орлого:** Өмнөх онд зохион байгуулагдаагүй дуудлага худалдааг тайлант онд нөхөн зохион байгуулсан тул орлого нэмэгдсэн.
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Өмнөх оны хүү торгуулийн орлогын дутууг нөхөн төлүүлсэнтэй холбоотойгоор орлого нэмэгдсэн.

Тасарсан орлогууд:

- ✓ **Малын тоо толгойн албан татвар:** 2022 оны малын тооллогод үндэслэн орлогыг төлөвлөлгүй хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалан орлого тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 5,828,325.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 3,549,546.8 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 178,668.9 мянган төгрөг, ерөнхий орлогын дансны оны эхний үлдэгдлээс 1,072,742.8 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 3,500.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 683,295.6 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 215,000.0 мянган төгрөг зэрэг нийт нийт зардалд **5,524,085.2** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг хувь хүний орлогын албан татварын буцаалтын 33,630.4 мянган төгрөгөөр бууруулан **3,515,916.4** мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 325,530.7 мянган төгрөг, ерөнхий орлогын дансны оны эхний үлдэгдлээс 1,559,344.4 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 7,275.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 825,278.4 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 272,600.0 мянган төгрөг зэрэг нийт орлого, зарлагыг тус бүр **6,505,945.6** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 4,542,289.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 825,278.4 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангаас 123,254.1 мянган төгрөг зэрэг нийт **5,490,821.5** мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн зардлын гүйцэтгэл **5,331,616.3** мянган төгрөг буюу **81.9** хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин, НДШ-ийн зардал 137,468.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,620.9 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 20,309.7 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 28,173.9 мянган төгрөгөөр, томилолтын зардал 192.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 7,315.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 83,867.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 27,908.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 13 төсөл, арга хэмжээнд 894,396.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 10 төсөл арга хэмжээний 355,187.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 539,209.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 20 төсөл, арга хэмжээнд 1,058,554.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 13 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 766,349.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож төлөвлөсөн төсөл арга хэмжээ 65.0 хувь хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 1,368.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 2,166.6 мянган төгрөг, судалгааны зардлын 1,300.0 мянган

төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулга, уулзалтын зардалд 1,200.0 мянган төгрөг, хамтарсан багийн 1,200.0 мянган төгрөг, тендерийн орлогоор 1,190.0 мянган төгрөг, Биеийн тамирын спортын газраас спортын тэмцээний зардалд 2,930.0 мянган төгрөг, сумын өвсний фондын орлогоос 14,215.0 мянган төгрөг зэрэг нийт **25,569.7** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс мал тооллогын зардалд 2,166.6 мянган төгрөг, судалгааны зардалд 1,300.0 мянган төгрөг, хүүхдийн чуулганы болон хамтарсан багийн зардалд 2,400.0 мянган төгрөг, өвсний нөөц бүрдүүлэхэд 14,215.0 мянган төгрөг, ахмадын арга хэмжээ, алтан намар арга хэмжээний зардалд 1,368.1 мянган төгрөг, тендерийн баримт бичиг боловсруулах зардалд 1,190.0 мянган төгрөг, спортын тэмцээний зардалд 2,930.0 мянган төгрөг зэрэг нийт **25,569.7** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	10	909,011.9	8	540,511.9	2	368,500.0
Сумын ОНХО	8	817,401.6	6	315,159.9	2	502,241.7

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн ХА ажиллагааны төлөвлөгөө тайлан

ЗДТГ, Хот тохижилтын газар нь нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнасан боловч шууд худалдан авах босго үнээс давсан 62,370.1 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Шунхлай ХХК компаниас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан ТТЗ-ийн сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материалыг орлогоор бүртгэж тайлагнаж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,887,953.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **68,879.5** мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал 34.5 хувиар буурсан тул аудитын явцад материаллаг байдлыг дахин хянаж, 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 4,507,575.9 мянган төгрөгийн 1 хувиар тооцон 45,075.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Автомашинуудад цэнхэр дэвсгэр бүхий дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	178	-	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	182	-	-
3	Засаг даргын Тамгын газар	182	182	-	-
	Нийт дүн	542	542	-	-

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнасан боловч шууд худалдан авах босго үнээс давсан нийт 62,370.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Шунхлай ХХК компаниас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ЗДТГ нь 29,170.0 мянган төгрөг,
- Хот тохижилтын газар нь 33,200.0 мянган төгрөг,

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа - 20.0 сая төгрөг ажил 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин,

дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,256.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 9,326.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	15,256.2	3	15,256.2	100
Зөвлөмж	3	9,326.0	3	9,326.0	100
Нийт дүн	6	24,582.2	6	24,582.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 2011-2019 онуудад олгогдсон, хугацаа хэтэрсэн, /зээлийн үлдэгдлийг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандсан, эвлэрлийн гэрээ байгуулсан, зээл төлүүлэх мэдэгдэх хуудсыг өгч ажиллаж байгаа хэдий ч/ зээлийн үлдэгдлийг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээг хангалттай аваагүй байна. Уг зээлийг барагдуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангасан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **20,668.3** мянган төгрөгийн алдаа илэрч 6,453.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 14,215.0 мянган төгрөгийн алдааг залруулах зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

Залруулсан алдаа / 6,453.3 мянган төгрөг /

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **6,453.3** мянган төгрөгийн дараах алдаа илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. ЗДТГ нь тайлант онд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцоогүйгээс нийт 5,814.7 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлж тайлагнасан.

2. ИТХ нь санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл нь эд хариуцагчийн тайлангийн эхний үлдэгдлээс 638.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан.

Залруулаагүй алдаа : **ЗДТГ** /14,215.0 мянган төгрөг/

ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансны орлогын эх үүсвэрээр бэлтгэсэн 14,215.0 мянган төгрөгийн нөөцийн өвсийг бараа материалын дансанд орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй байна. /2187 ширхэг, тус бүр 6,5 мянган төгрөгийн үнэтэй өөс/

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын бүртгэлийг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **35,341.5** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **34,266.5** мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, **1,075.0** мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

ИТХ:

1. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын батлагдсан төсвөөс дэлхийн ЖИЗҮЦҮ бөхийн аварга Б.Дэлгэрсайханд **400.0** мянган төгрөгийн шагнал олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ын *Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. ОНХС-ийн дансанд төвлөрсөн тодорхойгүй орлогын шалтгааныг тодруулж, төлбөр тооцоог тухай бүр хянаж залруулаагүйгээс **4,208.9** мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог тухай бүр хянаж, өр төлбөр үүсгэлгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Үр дүнг тооцсон гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **29,657.6** мянган төгрөгийн ажил, гүйлгээний хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бараа материалын дансад бүртгэлгүй, шууд зардлаар бүртгэж, тайлагнасан байна. Үүнд:

- ИТХ нь ГХУС арга хэмжээний зардлаас зарцуулсан 240.0 мянган төгрөгийн түлш шатахуун,
- ЗДТГ нь Засаг даргын нөөц болон гамшгийн зардлаас зарцуулсан 9,687.6 мянган төгрөгийн түлш шатахуун,
- Хот тохижилтын газар нь ОНХО-ын санхүүжилтээр хийгдсэн хур хог хаягдлыг зайлуулж, устгах төсөл арга хэмжээний 19,730.0 мянган төгрөг гэх зэрэг.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын хөдлөл өөрчлөлтийн ажил гүйлгээг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр тухай бүр гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж:

1. ЖМС-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: ИТХ нь ЖМС-ийн **1,075.0** мянган төгрөгийн зарцуулалтын тайланг журмын дагуу бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”*-ын 2.7 дахь заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: ЖМС-ийн тайланг холбогдох журмын дагуу гаргаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	638.6	1	638.6			1	638.6				
ЗДТГ	2	20,029.7	2	20,029.7			1	5,814.7	1	14,215.0	1	14,215.0
Дүн	3	20,668.3	3	20,668.3			2	6,453.3	1	14,215.0	1	14,215.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
							Тоо	Дүн				
Сайхан сумын ТТЗ	4	35,341.5			3	34,266.5	1	1,075.0				
Дүн	4	35,341.5			3	34,266.5	1	1,075.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Дүн
							Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ЗДТГ нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	62,370.0			1	62,370.0				
Дүн	1	62,370.0			1	62,370.0				
Нийт дүн	1	62,370.0			1	62,370.0				



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 259/Н1840393
СНН-2024/Н-НН-СЖА-ТТЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар шууд худалдан авах босго үнээс давсан нийт **62,370.0** мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Шунхлай ХХК компаниас шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн. Үүнд:

- ЗДТГ нь 29,170.0 мянган төгрөг,
- Хот тохижилтын газар нь 33,200.0 мянган төгрөг,

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20.0 сая төгрөг ажил 20.0 сая төгрөг" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: "4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн алдаа ... бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

013040806

2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сайхан сумын Засаг дарга Б.Мөнхболд, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Гарамбазар болон холбогдох төсвийн шууд захирагч, нягтлан бодогчдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

АУДИТОР



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 238/А1870393
СЭА-2024/11-НН-ОА-ТТЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар үр дүнг тооцсон гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **29,657.6** мянган төгрөгийн ажил, гүйлгээний хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бараа материалын дансад бүртгэлгүй, шууд зардлаар бүртгэж, тайлагнасан зөрчил илэрлээ. Үүнд:

- ИТХ нь ГХУС арга хэмжээний зардлаас зарцуулсан 240.0 мянган төгрөгийн түлш шатахуун,
- ЗДТГ нь Засаг даргын нөөц болон гамшгийн зардлаас зарцуулсан 9,687.6 мянган төгрөгийн түлш шатахуун,
- Хот тохижилтын газар нь ОНХО-ын санхүүжилтээр хийгдсэн хур хог хаягдлыг зайлуулж, устгах төсөл арга хэмжээний 19,730.0 мянган төгрөг.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх ".... байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь.... аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад.... баталгаажуулна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: "4.2.1.1: "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

018040804

1. Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийн ажил гүйлгээг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр тухай бүр гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сайхан сумын Засаг дарга Б.Мөнхболд, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Гарамбазар болон холбогдох төсвийн шууд захирагч, нягтлан бодогчдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 254/А/840393
СГА-2024/11-Д/А-СГА-ТБ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар сумын ОНХС-ийн дансанд төвлөрсөн тодорхойгүй орлогын учир шалтгаан, хариуцагчийг тодорхойлж, төлбөр тооцоог хянаж, залруулаагүйгээс **4,208.9** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,.....” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ”4.2.1.7: “Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.”, 4.2.1.11: “Хууль, тогтоомж..... зөрчсөн” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн төлбөр тооцоог тухай бүр хянаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сайхан сумын Засаг дарга Б.Мөнхболд, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Гарамбазар болон ОНХС-ийн нягтлан бодогч Б.Уранбилэг нарт даалгав.

018040800

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 258/АБ 70393
СЭА-2024/Н-НА-СЭА-ТТЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ИТХ-ын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын батлагдсан төсвөөс дэлхийн ЖИЗҮЦҮ бөхийн аварга Б.Дэлгэрсайханд 400.0 мянган төгрөгийн шагнал олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу **албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох** мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.6: “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сайхан сумын Засаг дарга Б.Мөнхболд, Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон


018040797

гүйцэтгэгч С.Гарамбазар болон ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Батмөнх,
нягтлан бодогч Б.Уранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

